



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 25-өдөр

Дугаар № 55

Мандалговь

Г Сургалт зохион байгуулах тухай Т

Засгийн газрын 2008 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-ын 21-ийн “Г” дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 25-ний өдрийн 11 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийг зарлан дуудаж цэргийн анхан шатны мэдлэг эзэмшүүлэх, гүйцэтгэх үүргийн мэдлэг, дадлага эзэмшүүлэх сургалтанд 2017 оны 07 дугаар 05-наас 08 дугаар сарын 07-ний хооронд зохион явуулсугай.

Хоёр. Сургалтыг хөтөлбөрийн дагуу чанартай зохион байгуулж явуулахыг Цэргийн штабт даалгасугай.

Гурав. Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдийн сургалтын зардалд шаардагдах 2.502.094 /хоёр сая таван зуун хоёр мянга ерэн дөрөв/ төгрөгийг Засаг даргын нөөцөөс гаргахдаа зохих урьдчилгаа олгож гүйцэтгэлээр тооцоо хийхийг аймгийн ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

Дөрөв. Засгийн газрын 2008 оны 49 дүгээр тогтоолын 9, 10-ын “Е”, 25 дах заалтуудыг тус тус үндэслэн цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдийг аймаг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалтын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулан осол авааргүй зохион байгуулалттайгаар оролцуулахыг Цэргийн штабын даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О БАТ-ЭРДЭНЭ

0200731